



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10 нэрийн нийт 8,249,025.07 (найман сая хоёр зуун дөчин есөн мянга хорин таван төгрөг долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж тажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201836

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дүгээр сарын 08-ны өдрийн
7.5 дугаар албан тоотын хавсралт

**"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалта д орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	5 ханатай гэр	ш	1	2010.06.30	1,200,000.00	1,200,000.00
2	Люминесценцын аппарат	ш	1	2000.06.30	18,000.00	18,000.00
3	Суцельны шкаф/хатаагч шүүгээ	ш	1	2004.01.01	652,147.20	652,147.20
4	Микроскоп	ш	1	2004.01.01	1,011,574.07	1,011,574.07
5	Шлиф хатаагч ширээ	ш	1	2004.01.01	2,446,187.75	2,446,187.75
6	Принтер	ш	1	2011.09.30	171,666.67	171,666.67
7	Стерео микроскоп	ш	1	2004.01.01	168,540.34	168,540.34
8	Байршил тодорхойлогч GPS	ш	1	2011.12.31	200,909.04	200,909.04
9	Принтер А3	ш	1	2015.04.03	580,000.00	580,000.00
10	Принтер	ш	1	2016.12.31	1,800,000.00	1,800,000.00
			10			8,249,025.07
	НИЙТ ДҮН				(найман сая хоёр зуун дөчин есөн мянга хорин таван төгрөг долоон мөнгө)	